



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/106/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhant@audit.gov.mn">Batsaikhant@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Azure Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: <a href="mailto:audit@azure.mn">audit@azure.mn</a></p>
----------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
3.1 Зөвлөмж .....	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ О.ГАНЦЭЦЭГ ТАНАА

2026.02.24

№

45

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Луус сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 176,610.7 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн балансаас баланст хөрөнгө шилжүүлсэн авсантай холбоотой үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 75,750.1 мянган төгрөгөөр өсжээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж

4826050148

үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>161,407,216.00</b>	<b>152,750,756.84</b>
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	161,407,216.00	152,750,756.84
31210	Төгрөг	161,407,216.00	152,750,756.84
31211	Төрийн сангийн харилцах	152,980,607.83	152,750,756.84
31218	Ахмадын сангийн харилцах	8,426,608.17	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>396,220.00</b>	<b>4,066,708.17</b>
33300	Тагаас, санхүүжилтийн авлага	-	4,066,708.17
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>57,872,045.77</b>	<b>41,951,081.98</b>
35100	Түүхий эд материал	35,812,182.67	24,797,367.96
35110	Тусгай зориулалттай материал	35,509,703.17	24,460,651.96
35130	Эм боох материал	302,479.50	336,716.00
35400	Хангамжийн материал	22,059,863.10	17,153,714.02
35410	Бичиг хэргийн материал	2,523,300.00	1,459,500.00
35420	Аж ахуйн материал	14,639,840.00	9,145,387.62
35460	Хүнсний материал	4,896,723.10	6,548,826.40
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>219,675,481.77</b>	<b>198,768,546.99</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,576,361,846.17</b>	<b>1,652,111,965.09</b>
39200	Биет хөрөнгө	1,530,071,174.49	1,606,607,177.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,397,926,676.10	1,435,339,077.10
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(66,439,917.36)	(118,705,351.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,900,000.00	29,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(14,950,000.20)	(17,940,000.24)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	236,776,122.45	247,831,122.45
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(114,500,122.85)	(72,004,211.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	109,060,141.22	112,422,141.22
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(66,361,898.29)	(27,110,854.77)
39217	Номын фонд	18,660,173.42	16,875,254.49
39300	Биет бус хөрөнгө	46,290,671.68	45,504,787.84
39301	Программ хангамж	3,929,420.00	3,929,420.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(1,702,748.32)	(2,488,632.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,064,000.00	44,064,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>1,576,361,846.17</b>	<b>1,652,111,965.09</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>1,796,037,327.94</b>	<b>1,850,880,512.08</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>18,548,000.00</b>	<b>800,000.00</b>
41300	Өглөг	18,548,000.00	800,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	800,000.00
413204	Цэвэр, бохир усны өглөг	-	800,000.00
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>18,548,000.00</b>	<b>800,000.00</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,777,489,327.94</b>	<b>1,850,080,512.08</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	251,816,170.00	251,816,170.00
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	251,816,170.00	251,816,170.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,312,466,758.04	1,385,057,942.18
51210	Өмнөх үеийн үр дүн	1,312,466,758.04	1,312,471,758.04
51220	Тайлант үеийн үр дүн	-	72,586,184.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	213,206,399.90	213,206,399.90
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>1,777,489,327.94</b>	<b>1,850,080,512.08</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>1,796,037,327.94</b>	<b>1,850,880,512.08</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,210,603,700.00</b>	<b>1,354,672,800.00</b>
1310	Улсын төсвөөс	1,110,472,400.00	1,249,916,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,110,472,400.00	1,249,916,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,131,300.00	104,756,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	100,131,300.00	104,756,100.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>1,110,040,527.60</b>	<b>203,696,148.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	1,110,040,527.60	203,696,148.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,599,025.60	17,623,033.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	779,200.00	1,182,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	18,819,825.60	16,440,333.90
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,087,144,486.00	177,484,498.28
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	3,297,016.00	8,588,615.82
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,320,644,227.60</b>	<b>1,558,368,948.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,199,824,441.52</b>	<b>1,483,808,702.22</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,182,262,998.76	1,458,238,625.72
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	844,568,820.00	1,021,179,516.00
210101	Үндсэн цалин	404,581,582.00	611,617,145.00
210102	Нэмэгдэл	386,085,678.00	320,352,351.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	34,265,000.00
210104	Урамшуулал	53,901,560.00	54,945,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,125,326.11	113,465,596.08
210201	Тэтгэврийн даатгал	66,661,882.65	77,293,212.65
210202	Тэтгэмжийн даатгал	8,126,584.15	10,164,539.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,866,485.12	5,043,331.62
210204	Ажилгүйдлийн даатгал	5,050,260.42	4,292,691.05
210205	Эрүүл мэндийн даатгал	13,420,113.77	16,671,821.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,463,656.44	96,312,227.50
210301	Гэрэл, цахилгаан	6,695,266.74	8,903,837.80
210302	Түлш, халаалт	79,692,389.70	79,692,389.70
210303	Цэвэр, бохир ус	4,076,000.00	7,716,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,214,970.00	39,554,478.41
210401	Бичиг хэрэг	1,708,500.00	6,205,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,001,360.00	2,206,379.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,505,110.00	15,040,250.00
210408	Бараа материал акталсны зардал	-	16,102,049.41
2105	Нормативд зардал	33,198,073.20	42,750,314.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,240.50	55,763.50
210502	Хоол, хүнс	33,106,832.70	42,694,550.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,403,500.00	9,943,500.00
210604	Урсгал засвар	15,403,500.00	9,943,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,261,546.90	9,041,235.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,127,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,261,546.90	7,913,535.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,027,106.11	125,991,757.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,621,031.26	21,905,240.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,639,700.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	71,766,374.85	104,086,517.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,561,442.76	25,570,076.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,532,371.50	24,760,204.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,009,371.50	21,880,204.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,523,000.00	2,880,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,071.26	809,872.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,071.26	809,872.50
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>1,199,824,441.52</b>	<b>1,483,808,702.22</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>1,120,819,786.08</b>	<b>74,560,245.78</b>

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	1,596,433.50	1,974,061.64
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,596,433.50	1,974,061.64
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,596,433.50</b>	<b>1,974,061.64</b>
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>1,119,223,352.58</b>	<b>72,586,184.14</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,210,603,700.00</b>	<b>1,354,672,800.00</b>
1310	Улсын төсвөөс	1,110,472,400.00	1,249,916,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,110,472,400.00	1,249,916,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,131,300.00	104,756,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	100,131,300.00	104,756,100.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>19,564,025.60</b>	<b>17,503,033.90</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	19,564,025.60	17,503,033.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,564,025.60	17,503,033.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	779,200.00	1,182,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	18,784,825.60	16,320,333.90
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,230,167,725.60</b>	<b>1,372,175,833.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,124,476,143.67</b>	<b>1,376,506,093.06</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,102,548,938.41	1,342,662,590.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	844,753,949.17	1,021,015,151.00
210101	Үндсэн цалин	525,702,080.17	611,452,780.00
210102	Нэмэгдэл	262,193,924.00	320,352,351.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	34,265,000.00
210104	Урамшуулал	56,857,945.00	54,945,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,120,916.94	113,429,241.08
210201	Тэтгэврийн даатгал	65,154,300.00	77,256,857.65
210202	Тэтгэмжийн даатгал	7,988,800.00	10,164,539.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,944,400.00	5,043,331.62
210204	Ажилгүйдлийн даатгал	4,044,400.18	4,292,691.05
210205	Эрүүл мэндийн даатгал	15,989,016.76	16,671,821.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,302,728.74	95,512,227.50
210301	Гэрэл, цахилгаан	6,695,266.74	8,903,837.80
210302	Түлш, халаалт	84,531,462.00	79,692,389.70
210303	Цэвэр, бохир ус	4,076,000.00	6,916,000.00
2105	Нормативд зардал	23,471,685.00	35,590,846.00
210502	Хоол, хүнс	23,471,685.00	35,590,846.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,299,500.00	9,932,300.00
210604	Урсгал засвар	6,299,500.00	9,932,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,813,653.56	11,617,235.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	779,200.00	1,127,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,034,453.56	10,489,535.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,786,505.00	55,565,589.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,723,305.00	52,051,189.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,063,200.00	3,514,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,927,205.26	33,843,502.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,898,134.00	28,966,922.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,375,134.00	24,009,422.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,523,000.00	4,957,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,071.26	809,872.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,071.26	809,872.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,066,708.17

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,066,708.17
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>1,124,476,143.67</b>	<b>1,376,506,093.06</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>105,691,581.93</b>	<b>(4,330,259.16)</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,642,000.00</b>	<b>4,326,200.00</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	17,642,000.00	4,326,200.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	17,642,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,642,000.00	4,326,200.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>17,642,000.00</b>	<b>4,326,200.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	<b>(17,642,000.00)</b>	<b>(4,326,200.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	<b>88,049,581.93</b>	<b>(8,656,459.16)</b>
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>73,357,634.07</b>	<b>161,407,216.00</b>
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>161,407,216.00</b>	<b>152,750,756.84</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>251,816,170.00</b>	<b>213,992,726.10</b>	<b>192,457,079.26</b>	<b>658,265,975.36</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	786,326.20	786,326.20
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>251,816,170.00</b>	<b>213,992,726.10</b>	<b>193,243,405.46</b>	<b>659,052,301.56</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(786,326.20)	-	(786,326.20)
Тайлант үеийн үр дүн	-	-	1,119,223,352.58	1,119,223,352.58
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>251,816,170.00</b>	<b>213,206,399.90</b>	<b>1,312,466,758.04</b>	<b>1,777,489,327.94</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,000.00	5,000.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>251,816,170.00</b>	<b>213,206,399.90</b>	<b>1,312,471,758.04</b>	<b>1,777,494,327.94</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	72,586,184.14	72,586,184.14
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>251,816,170.00</b>	<b>213,206,399.90</b>	<b>1,385,057,942.18</b>	<b>1,850,080,512.08</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>1,528,568,900.00</b>	<b>1,354,672,800.00</b>	<b>21,135,000.00</b>
Улсын төсвөөс	1,423,812,800.00	1,249,916,700.00	21,135,000.00
Орон нутгийн төсвөөс	104,756,100.00	104,756,100.00	-
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>16,420,000.00</b>	<b>17,503,033.90</b>	<b>(1,083,033.90)</b>
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	16,420,000.00	17,503,033.90	(1,083,033.90)
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,544,988,900.00</b>	<b>1,372,175,833.90</b>	<b>20,051,966.10</b>
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,285,943,000.00	1,134,444,392.08	151,498,607.92
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,143,060,500.00</b>	<b>1,021,015,151.00</b>	<b>122,045,349.00</b>
Цалин	644,721,300.00	611,452,780.00	33,268,520.00
Цалингийн тусгай нэмэгдлүүд	498,339,200.00	409,562,371.00	88,776,829.00
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>142,882,500.00</b>	<b>113,429,241.08</b>	<b>29,453,258.92</b>

Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	120,021,400.00	96,757,420.03	23,263,979.97
Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,861,100.00	16,671,821.05	6,189,278.95
<b>Бараа ,үйлчилгээний урсгал зардал</b>	<b>259,045,900.00</b>	<b>237,151,420.31</b>	<b>21,894,479.69</b>
Тогтмол зардал	<b>96,322,100.00</b>	<b>95,512,227.50</b>	<b>809,872.50</b>
Гэрэл цахилгааны зардал	11,830,000.00	8,903,837.80	2,926,162.20
Түлш, халаалтын зардал	79,692,100.00	79,692,389.70	(289.70)
Цэвэр, бохир усны зардал	4,800,000.00	6,916,000.00	(2,116,000.00)
<b>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</b>	<b>162,723,800.00</b>	<b>141,639,192.81</b>	<b>21,084,607.19</b>
Хоол	42,824,600.00	35,590,846.00	7,233,754.00
Бусад бараа үйлчилгээний зардал	57,980,100.00	52,017,489.00	5,962,611.00
Шуудан холбооны зардал	11,327,600.00	10,489,535.81	838,064.19
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,548,000.00	3,514,400.00	33,600.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,200,000.00	1,127,700.00	72,300.00
Урсгал засварын зардал	10,434,000.00	9,932,300.00	501,700.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	4,958,300.00	4,957,500.00	800.00
Бусад /үдийн цай/	30,451,200.00	24,009,422.00	6,441,778.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	809,872.50	(809,872.50)
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,544,988,900.00</b>	<b>1,372,405,684.89</b>	<b>172,583,215.11</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	152,980,607.83	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	152,750,756.84	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 495.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 495.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Зөвлөмж

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Боловсролын газрын 2025 оны Б/96 тоот тушаалаар сургуулийн захирлын түр орлон гүйцэтгэгчид олгосон урамшууллаас 28.5 мянган төгрөгийн татварыг суутгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т (*ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого*), 25 дугаар зүйлийн 25.4-т (*Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ*) заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж, олгосон урамшууллаас татварыг суутгаж ажиллах.

Илрүүлэлт 2: Сургуулийн захирлын 2025 оны А/27 тоот тушаалаар олгосон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас 467.2 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т (*ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого*), 25 дугаар зүйлийн 25.4-т (*Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар*

*төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ) заасныг тус тус зөрчсөн байна.*

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж, олгосон урамшууллаас татварыг суутгаж, татварын тайланд тайлагнаж ажиллах.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100 хувийг залруулагдаагүй зөрчил эзэлж байна. Нийт 495.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь нийцлийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх зөрчил байхгүй тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Боловсролын газрын 2025 оны Б/96 тоот тушаалаар сургуулийн захирлын түр орлон гүйцэтгэгчид олгосон урамшууллаас татварыг суутгаагүй байна.	1	28.5	-	-	-	-	1	28.5	-	-
Сургуулийн захирлын 2025 оны А/27 тоот тушаалаар олгосон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж тайлагнаагүй байна.	1	467.2	-	-	-	-	1	467.2	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>495.7</b>	-	-	-	-	<b>2</b>	<b>495.7</b>	-	-